



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 614

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн 0108 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2018 оны 58-07-007/37 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, нийт 95,620,332.53 (ерэн таван сая зургаан зуун хорин мянга гурван зуун гучин хоёр төгрөг тавин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 62,099,888.51 (жаран хоёр сая ерэн есөн мянга найман зуун наян найман төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Ц.Сэргэлэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг, материал болгон ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн
6.14 дугаар тогтоолын хавсралт

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХИЛИЙН 0108 ДУГААР АНГИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Уулзалтын байр	ш	1	1980.07.13	77,641,200.00	48,526,563.16	29,114,636.84
2	Хилийн постын уурын зуух	ш	1	1990.07.13	1,404,000.00	643,510.05	760,489.95
3	Уурын зуухны тогоо	ш	1	2013.04.30	2,000,000.00	2,000,000.00	-
4	Сэндвичэн барилга	ш	1	2015.01.30	7,342,991.10	4,834,135.81	2,508,855.29
5	Хашаа -автозамын	ш	1	2015.01.30	3,544,329.46	2,599,175.04	945,154.42
6	Уурын зуухны тогоо	ш	4	2010.09.19	956,536.00	765,228.48	191,307.52
7	Постын хашаа (ШХЗ-ын)	ш	1	1986.01.13	1,101,955.97	1,101,955.97	-
8	Цамхаг /Пишиж/	ш	3	1988.07.13	1,629,320.00	1,629,320.00	-
	Нийт дүн				95,620,332.53	62,099,888.51	33,520,444.02
					(ерэн таван сая зургаан зуун хорин мянга гурван зуун гучин хоёр төгрөг тавин гурван мөнгө)	(жаран хоёр сая ерэн есөн мянга найман зуун наян найман төгрөг тавин нэгэн мөнгө)	(гучин гурван сая таван зуун хорин мянга дөрвөн зуун дөчин дөрвөн төгрөг хоёр мөнгө)